



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 398,000,000.00 (гурван зуун ерэн найман сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автобусыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын ерөнхий захирал А.Эрдэнэтуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны... дугаар сарын... ний өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

"ЭХ , НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁР"-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/
1	Автобус хуандай койнти 202109 арлын дугаар КМЈНГ17ВРNC500597	2021.09	277	199,000,000.00
2	Автобус хуандай нэв койнти 202203 арлын дугаар КМЈНГ17ВРNC500867	2022.03	263	199,000,000.00
НИЙТ ҮНЭ				398,000,000.00 (гурван зуун ерэн найман сая)